



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2006 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 486

Улаанбаатар хот

Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 1, 3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 196 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Бүтэц, зохион байгуулалтыг шинэчилсэнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд барилга, хот байгуулалт, дэд бүтэц, газрын харилцааны талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий ба хэсэгчилсэн төлөвлөгөө, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах хэрэгжилтэнд нь хяналт тавих, хот байгуулалтын мэдээллийн санг бүрдүүлэх, төвлөрсөн ба нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, бусад хөрөнгийн эх үүсвэр бүхий улсын болон нийслэлийн захиалгатай объектын батлагдсан хөрөнгийн зарцуулалт, шинээр баригдах барилга байгууламжинд тавих техникийн хяналт, үр ашгийг дээшлүүлэх чиг үүрэг бүхий Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрыг 2006 оны 10 дугаар сарын 6-ны өдрөөс байгуулсугай.

Хоёр. Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрыг Тамгын хэлтэс, Хот байгуулалтын хэлтэс, Барилга, хөрөнгө оруулалтын хэлтэс, Хот төлөвлөлт, мэдээллийн хэлтэстэйгээр ажиллуулж орон тооны хязгаарыг 48 хүртэл / үүнээс удирдлага 3/ байхаар тогтоосугай.

Гурав. Улаанбаатар хотын ерөнхий архитектор Нэргүйн Нацагдоржийг 2006 оны 10 дугаар сарын 9-ний өдрөөс Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын даргаар томилж, сарын үндсэн цалинг 208000 /хоёр зуун найман мянган/ төгрөгөөр тогтоосугай.

Дөрөв. Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар байгуулагдсантай холбогдуулан Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг “Хөрөнгө оруулалтын газар”-ыг 2006 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.

Тав .Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолын 5 дугаар заалтын дагуу Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнг Улаанбаатар хотын Захирагчийн харьяанд ажиллуулж, тус хүрээлэнгийн бүтцэд байгаа Мэдээллийн төвийг Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын Хот төлөвлөлт, мэдээллийн хэлтэст нэгтгэсүгэй.

Зургаа. Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын дүрмийг батлуулах, ажлын байрны тодорхойлолт гаргах, албан хаагчдыг ажилд томилох, төсвийн Ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулах зэрэг асуудлыг 2006 оны 10 дугаар сарын 20-ны дотор шийдвэрлэхийг Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар /Н.Нацагдорж/-т үүрэг болгосугай.

Долоо. Бүтцийн өөрчлөлт хийгдсэн холбогдох байгууллагуудад ажиллаж байсан албан хаагчдыг ажлын байраар хангахыг Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газар /Н.Нацагдорж/, шинээр байгуулагдсан газрын конторын байрны асуудлыг зохицуулахыг Нийтлэг үйлчилгээний газар /Т.Дашням/, Хөрөнгө оруулалтын газар болон Мэдээллийн төвийн өмч, хөрөнгийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/-т тус тус даалгасугай.

Найм. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын орлогч Б.Баатарзориг-д үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.БАТБАЯР